



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/333/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261628 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Энхжин
Утас: 261628 Цахим хаяг: Enkhjinb@audit.gov.mn
Аудитор: Э.Бүгүнүтэй
Утас: 261628 Цахим хаяг: Bugunuteie@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.8.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4. Аудитын илрүүлэлт	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ОУЭЗХБ	Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УТҮГ	Улсын төсөв үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ, ЦАГДААГИЙН ХУРАНДАА
П.БАТБААТАР ТАНАА

2022.02.04 № 07/324
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дотоод хэргийн их сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дотоод хэргийн их сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,612,168,855.41	3,488,203,058.82
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	935,618,420.50	2,102,640.00
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	935,618,420.50	2,102,640.00
31210	Төгрөг	935,618,420.50	2,102,640.00
31211	Төрийн сангийн харилцах	935,618,420.50	2,102,640.00
33	АВЛАГА	17,682,424.00	25,482,424.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	7,800,000.00
33500	Бусад авлага	17,682,424.00	17,682,424.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	17,682,424.00	17,682,424.00
34	УРЬДЧИЛГАА	170,383,547.00	175,817,571.21
34600	Урьдчилж гарсан зардал	170,383,547.00	175,817,571.21
35	БАРАА МАТЕРИАЛ	3,488,484,463.91	3,284,800,423.61
35100	Түүхий эд материал	1,024,823,314.48	1,032,176,571.31
35110	Тусгай зориулалттай материал	914,418,073.61	981,137,918.61
35130	Эм боох материал	110,405,240.87	51,038,652.70
35300	Бэлэн бүтээгдэхүүн	793,535,896.25	765,368,349.10
35400	Хангамжийн материал	1,670,125,253.18	1,487,255,503.20
35410	Бичиг хэргийн материал	96,356,897.00	81,590,449.13
35420	Аж ахуйн материал	832,589,381.96	808,987,299.06
35430	Сэлбэг хэрэгсэл	62,151,460.00	54,361,160.00
35440	Түлш, шатах тослох материал	72,489,871.25	43,628,599.25
35450	Барилгын засварын материал	331,511,072.00	175,357,171.00
35460	Хүнсний материал	190,134,192.97	233,232,825.96
35470	Бусад хангамжийн материал	84,892,378.00	90,097,998.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	89,833,276,748.02	88,160,457,508.38
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	89,833,276,748.02	88,160,457,508.38
39200	Биет хөрөнгө	75,578,890,180.11	73,330,700,883.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	69,821,650,906.50	69,840,493,906.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,591,054,257.45)	(4,983,754,304.54)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,168,181,202.00	2,191,681,202.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(809,270,929.79)	(1,047,590,238.52)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	6,625,731,363.29	6,753,658,660.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,176,405,116.00)	(2,933,218,476.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,070,413,033.60	3,201,212,603.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,476,303,035.54)	(1,817,066,130.71)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	355,709,130.00	371,609,130.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	(23,411,286.00)	(24,086,286.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,130,991,015.35	1,301,980,291.35
39215	Хуримтлагдсан элэгдэл	(223,348,576.70)	(280,683,504.53)
39217	Ном	706,006,730.85	756,464,030.85
39300	Биет бус хөрөнгө	14,254,386,567.91	14,829,756,624.71
39301	Программ хангамж	52,548,605.50	51,798,605.50
39302	Хуримтлагдсан элэгдэл	(38,444,817.59)	(42,300,120.79)
39303	Бусад биет бус хөрөнгө	14,240,282,780.00	14,820,258,140.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	94,445,445,603.43	91,648,660,567.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	935,618,420.50	9,902,640.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	935,618,420.50	9,902,640.00
41300	Өглөг	934,000,740.50	7,800,000.00
41360	Бусад өглөг	934,000,740.50	7,800,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	934,000,740.50	7,800,000.00
41400	Урьдчилж орсон орлого	1,617,680.00	2,102,640.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	1,617,680.00	2,102,640.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	93,509,827,182.93	91,638,757,927.20
51	Засгийн газрын хувь оролцоо	93,509,827,182.93	91,638,757,927.20

Дотоод хэргийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,588,860,843.91	5,588,860,843.91
51200	Хуримтлагдсан үр дүн	66,304,443,683.38	64,535,506,494.85
51210	Өмнөх үеийн үр дүн	42,180,309,522.32	66,406,575,750.58
51220	Тайлант үеийн үр дүн	24,124,134,161.06	(1,871,069,255.73)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	21,616,522,655.64	21,514,390,588.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	94,445,445,603.43	91,648,660,567.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	41,501,231,517.36	16,532,296,376.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,366,180,968.51	2,015,537,811.43
120	Нийтлэг татварын бус орлого	9,366,180,968.51	1,782,945,700.43
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,019,669,427.00	1,782,945,700.43
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	860,886,435.00	1,033,108,169.10
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,852,709.00	29,346,245.33
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,150,930,283.00	138,316,426.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	4,230,159,842.96	582,174,860.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	116,351,698.55	-
122	Тусламжийн орлого	-	232,592,111.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	232,592,111.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	32,135,050,548.85	14,516,758,564.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	30,915,221,740.00	14,193,602,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	14,817,150,700.00	14,193,602,200.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	16,098,071,040.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,219,828,808.85	323,156,364.90
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	26,535,000.00	63,086,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	967,417,900.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	225,875,908.85	260,070,364.90
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	17,377,097,356.30	18,403,365,632.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,377,097,356.30	18,403,365,632.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,523,067,104.42	17,287,576,454.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,250,741,394.00	9,250,147,657.00
210101	Үндсэн цалин	4,974,929,794.00	5,051,543,200.00
210102	Нэмэгдэл	4,045,876,400.00	3,968,669,257.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	229,935,200.00	229,935,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	785,409,786.42	885,479,120.36
210201	Тэтгэврийн даатгал	711,240,100.00	742,431,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	17,823,300.00	76,994,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,128,600.00	8,590,920.36
210204	Ажилгүйдлийн даатгал	282,000.00	2,271,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	54,935,786.42	55,190,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	510,057,991.24	576,988,378.03
210301	Гэрэл, цахилгаан	238,452,354.37	247,836,172.10
210302	Түлш, халаалт	216,236,963.00	246,654,215.93
210303	Цэвэр, бохир ус	55,368,673.87	82,497,990.00
2104	Хангамж, бараа материалын зардал	264,071,700.40	490,053,913.51
210401	Бичиг хэрэг	103,359,090.50	127,733,914.40
210402	Тээвэр, шатахуун	69,445,476.00	80,526,522.00

Дотоод хэргийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	28,978,518.90	20,889,164.01
210404	Ном, хэвлэл	17,515,014.00	4,719,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	44,773,601.00	54,365,709.00
210408	Бараа материал акталсны зардал	-	201,819,604.10
2105	Норматив зардал	2,013,687,776.23	2,022,857,283.23
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	179,766,062.73	161,701,614.17
210502	Хоол, хүнс	772,771,001.85	794,178,967.01
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,061,150,711.65	1,066,976,702.05
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	224,384,758.00	320,063,181.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,025,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	23,509,046.00	18,598,233.00
210604	Урсгал засвар	198,850,712.00	301,464,948.00
2107	Томилолт, зочны зардал	10,160,800.00	21,945,482.00
210701	Гадаад албан томилолт	8,207,800.00	20,810,482.00
210702	Дотоод албан томилолт	1,233,000.00	400,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	720,000.00	735,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	106,389,178.56	316,953,439.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,587,238.00	255,686,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	15,765,844.56	3,719,570.02
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,810,846.00	3,422,220.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	935,000.00	887,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	26,290,250.00	53,237,349.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,358,163,719.57	3,403,087,999.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,170,200.00	6,059,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	390,652,851.00	326,719,078.97
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,963,340,668.57	3,070,309,120.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,854,030,251.88	1,115,789,177.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,728,388,235.00	888,297,312.20
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,105,822.00	12,712,718.60
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,642,053.00	10,969,207.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	630,439,680.00	733,014,096.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,053,200,680.00	131,601,290.60
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	125,642,016.88	227,491,865.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,099,812.88	219,474,905.43
213304	Хөрөнгийн	8,539,204.00	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,000.00	8,016,959.77
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	24,124,134,161.06	(1,871,069,255.73)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	24,124,134,161.06	(1,871,069,255.73)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

					<i>/төгрөгөөр/</i>
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,588,860,843.91	21,616,522,655.64	42,180,309,522.32	69,385,693,021.87
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,588,860,843.91	21,616,522,655.64	42,180,309,522.32	69,385,693,021.87
9	Тайлант үеийн үр дүн	-	-	24,124,134,161.06	24,124,134,161.06
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,588,860,843.91	21,616,522,655.64	66,304,443,683.38	93,509,827,182.93
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,588,860,843.91	21,616,522,655.64	66,304,443,683.38	93,509,827,182.93
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	102,132,067.20	102,132,067.20
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,588,860,843.91	21,616,522,655.64	66,406,575,750.58	93,611,959,250.13
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(102,132,067.20)	-	(102,132,067.20)
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,871,069,255.73)	(1,871,069,255.73)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,588,860,843.91	21,514,390,588.44	64,535,506,494.85	91,638,757,927.20

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	33,938,014,433.35	15,579,697,939.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,802,963,884.50	1,062,939,374.43
120	Нийтлэг татварын бус орлого	1,802,963,884.50	1,062,939,374.43
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	868,963,144.00	1,062,939,374.43
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	861,110,435.00	1,033,593,129.10
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,852,709.00	29,346,245.33
120009	Бусад орлого	934,000,740.50	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	32,135,050,548.85	14,516,758,564.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	30,915,221,740.00	14,193,602,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	14,817,150,700.00	14,193,602,200.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	16,098,071,040.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,219,828,808.85	323,156,364.90
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	26,535,000.00	63,086,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	967,417,900.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	225,875,908.85	260,070,364.90
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,263,844,265.85	15,110,205,773.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,263,844,265.85	15,110,205,773.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,262,235,208.97	14,014,906,101.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,239,818,453.00	9,250,147,657.00
210101	Үндсэн цалин	4,964,006,853.00	5,051,543,200.00
210102	Нэмэгдэл	4,045,876,400.00	3,968,669,257.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	229,935,200.00	229,935,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	785,409,786.42	885,479,120.36
210201	Тэтгэврийн даатгал	711,240,100.00	742,431,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	17,823,300.00	76,994,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,128,600.00	8,590,920.36
210204	Ажилгүйдлийн даатгал	282,000.00	2,271,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	54,935,786.42	55,190,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	510,057,991.24	576,988,378.03
210301	Гэрэл, цахилгаан	238,452,354.37	247,836,172.10
210302	Түлш, халаалт	216,236,963.00	246,654,215.93
210303	Цэвэр, бохир ус	55,368,673.87	82,497,990.00
2104	Хангамж, бараа материалын зардал	299,124,161.90	152,146,714.01
210401	Бичиг хэрэг	26,570,600.00	24,050,000.00
210402	Тээвэр, шатахуун	133,625,900.00	50,178,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	28,978,518.90	20,989,164.01
210404	Ном, хэвлэл	17,944,812.00	11,223,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	92,004,331.00	45,706,200.00
2105	Нормативт зардал	2,358,136,485.85	2,030,635,564.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	274,402,631.00	93,577,500.00
210502	Хоол, хүнс	936,844,454.85	837,687,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,146,889,400.00	1,099,370,464.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	384,287,663.00	307,799,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,660,643.00	45,116,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	46,516,700.00	59,916,600.00
210604	Урсгал засвар	322,110,320.00	202,766,000.00
2107	Томилолт, зочны зардал	21,459,400.00	21,210,482.00
210701	Гадаад албан томилолт	8,207,800.00	20,810,482.00
210702	Дотоод албан томилолт	1,233,000.00	400,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	12,018,600.00	-

Дотоод хэргийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	126,697,060.56	350,874,660.23
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60,157,520.00	259,825,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	15,765,844.56	30,694,840.23
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,810,846.00	3,422,220.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	935,000.00	887,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	46,027,850.00	56,045,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	537,244,207.00	439,624,124.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,819,000.00	6,059,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	525,425,207.00	433,564,324.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,001,609,056.88	1,095,299,672.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,875,967,040.00	867,807,807.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,642,053.00	10,969,207.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	753,592,307.00	705,718,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,086,732,680.00	151,120,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	125,642,016.88	227,491,865.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,099,812.88	219,474,905.43
213304	Хөрөнгийн	8,539,204.00	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,000.00	8,016,959.77
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	17,674,170,167.50	469,492,166.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	16,739,945,427.00	1,403,007,946.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,739,945,427.00	1,403,007,946.50
2200	Дотоод эх үүсвэрээр	16,739,945,427.00	1,403,007,946.50
220001	Барилга байгууламж	16,089,531,836.00	-
223001	Бусад хөрөнгө	-	934,000,740.50
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	650,413,591.00	469,007,206.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(16,739,945,427.00)	(1,403,007,946.50)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	934,224,740.50	(933,515,780.50)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,393,680.00	935,618,420.50
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	935,618,420.50	2,102,640.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,060,709,600.00	15,036,581,709.00	24,127,891.00	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,060,709,600.00	15,036,581,709.00	24,127,891.00	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,192,901,700.00	14,168,773,902.00	24,127,798.00	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,239,777,800.00	9,239,347,657.00	430,143.00	100.0
210101	Үндсэн цалин	5,051,866,200.00	5,051,543,200.00	323,000.00	100.0
210102	Нэмэгдэл	3,957,976,400.00	3,957,869,257.00	107,143.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	229,935,200.00	229,935,200.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	885,974,200.00	885,479,120.36	495,079.64	99.9
210201	Тэтгэврийн даатгал	742,431,400.00	742,431,400.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	76,994,700.00	76,994,700.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,086,000.00	8,590,920.36	495,079.64	94.6
210204	Ажилгүйдлийн даатгал	2,271,300.00	2,271,300.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	55,190,800.00	55,190,800.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	577,123,500.00	576,988,378.03	135,121.97	100.0
210301	Гэрэл, цахилгаан	247,869,500.00	247,836,172.10	33,327.90	100.0
210302	Түлш, халаалт	246,743,900.00	246,654,215.93	89,684.07	100.0
210303	Цэвэр, бохир ус	82,510,100.00	82,497,990.00	12,110.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	192,448,900.00	191,992,514.01	456,385.99	99.8
210401	Бичиг хэрэг	22,585,000.00	22,585,000.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	50,178,100.00	50,178,100.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,165,000.00	20,989,164.01	175,835.99	99.2
210404	Ном, хэвлэл	57,814,600.00	57,534,050.00	280,550.00	99.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,706,200.00	40,706,200.00	-	100.0
2105	Нормативт зардал	1,933,295,200.00	1,933,295,200.00	-	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	93,577,500.00	93,577,500.00	-	100.0
210502	Хоол, хүнс	837,687,600.00	837,687,600.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,002,030,100.00	1,002,030,100.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	573,567,800.00	573,564,406.00	3,394.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	256,180,200.00	256,176,806.00	3,394.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	114,621,600.00	114,621,600.00	-	100.0
210604	Урсгал засвар	202,766,000.00	202,766,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	21,374,100.00	21,210,482.00	163,618.00	99.2
210701	Гадаад албан томилолт	20,901,000.00	20,810,482.00	90,518.00	99.6
210702	Дотоод албан томилолт	473,100.00	400,000.00	73,100.00	84.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	343,464,700.00	322,235,320.00	21,229,380.00	93.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	255,757,400.00	235,300,000.00	20,457,400.00	92.0
210803	Даатгалын үйлчилгээ	14,371,800.00	14,371,800.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,904,700.00	3,422,220.00	482,480.00	87.6
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,177,000.00	887,500.00	289,500.00	75.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	68,253,800.00	68,253,800.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	425,875,500.00	424,660,824.60	1,214,675.40	99.7

Дотоод хэргийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,059,800.00	6,059,800.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	419,815,700.00	418,601,024.60	1,214,675.40	99.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	867,807,900.00	867,807,807.00	93.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	867,807,900.00	867,807,807.00	93.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,969,300.00	10,969,207.00	93.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	705,718,600.00	705,718,600.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	151,120,000.00	151,120,000.00	-	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,060,709,600.00	15,178,489,995.40	(117,780,395.40)	100.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	14,214,059,600.00	14,116,035,580.97	98,024,019.03	99.3
310001	Улсын төсвөөс санхүүжих	14,214,059,600.00	14,116,035,580.97	98,024,019.03	99.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	846,650,000.00	1,062,454,414.43	(215,804,414.43)	125.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	840,750,000.00	1,033,108,169.10	(192,358,169.10)	122.9
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,900,000.00	29,346,245.33	(23,446,245.33)	497.4
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	995	995	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	497	497	-	100.0
620001	Удирдах ажилтан	5	5	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	422	422	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	70	70	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	497	497	-	100.0
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	434	434	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	63	63	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	323,156,364.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	323,156,364.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	315,139,405.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	10,800,000.00
210102	Нэмэгдэл	-	10,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	6,465,000.00
210401	Бичиг хэрэг	-	1,465,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	5,000,000.00
2105	Норматив зардал	-	97,340,364.90
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	97,340,364.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	78,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	78,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	40,848,040.23
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	24,525,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	16,323,040.23
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	81,686,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	81,686,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	8,016,959.77
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	8,016,959.77
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	8,016,959.77
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	323,156,364.90
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	323,156,364.90
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	63,086,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	260,070,364.90

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дотоод хэргийн их сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримтын бүрдлийг хангахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Б.Энхжин, аудитор Э.Бүгүнүтэй нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Дотоод хэргийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/87 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дотоод хэргийн их сургуулийн зорилгыг “Нийгэмд шударга ёсыг тогтоох чин эрмэлзэл, төлөвшил бүхий иргэнийг бэлтгэх, аюулгүй байдал, хууль зүй, дотоод хэргийн салбарын мэдлэг оюуны төв байна” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хэргийн их сургууль нь Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албатай бөгөөд 2021 оны дотоод аудитын жилийн төлөвлөгөөнд тусгасны дагуу дотоод аудитын чиглэлээр нийт 11 ажил, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн зарим үйл ажиллагаанд хэсэгчилсэн шалгалт 4, бусад нэгжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудит 6, бусад ажил 5, нийт 15 хяналт, шалгалтыг зохион байгуулж, 95.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дотоод хэргийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 2.0 хувиар буюу 830,024.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дотоод хэргийн их сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,796,785.0 мянган төгрөгөөр буюу 3.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /төгрөгөөр/
Мөнгөн хөрөнгө	935,618.4	2,102.6	(933,515.8)
Авлага	17,682.4	25,482.4	7,800.0
Урьдчилгаа	170,383.5	175,817.6	5,434.0
Бараа материал	3,488,484.5	3,284,800.4	(203,684.0)
Үндсэн хөрөнгө	89,833,276.7	88,160,457.5	(1,672,819.2)
Нийт хөрөнгийн дүн	94,445,445.6	91,648,660.6	(2,796,785.0)
Нийт өр төлбөр	935,618.4	9,902.6	(925,715.8)
Засгийн газрын хувь оролцоо	93,509,827.2	91,638,757.9	(1,871,069.3)
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	94,445,445.6	91,648,660.6	(2,796,785.0)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,102.6 мянган төгрөг болж өмнөх оноос 933,515.8 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгө оруулалтын ажлын барьцаа хөрөнгийг чөлөөлсөнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,284,800.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 203,684.1 мянган төгрөгөөр буурсан нь Ковид-19 цар тахлын улмаас улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор танхимаар сурах суралцагчдын тоо буурснаар худалдан авалт багассан, 384 нэр төрлийн 201,819.6 мянган төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан зэргээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө улсын төсвөөс бэлтгэсэн 469,007.2 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 139,028.8 мянга, дотоодын хандиваар бий болсон 209,478.5 мянган хөрөнгө, ТӨБЗГ-ын 2021 оны 689 тоот албан бичгээр 79,975.4 мянган төгрөгийн үнэ бүхий газрыг балансаас баланст шилжүүлсэн дүнгээр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2021 оны 211 тогтоолоор 279,848.1 мянган төгрөгийн хөрөнгийг

акталсан болон хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 102,132.1 мянган төгрөгөөр тус тус хасагджээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 9,902.6 мянган төгрөг болж өмнөх оноос 933,515.8 мянган төгрөгөөр буурсан нь барьцаа дэнчингийн урьдчилж орсон орлого дансанд бүртгэгдсэн 2 гүйцэтгэгч байгууллагын хөрөнгө оруулалтын барьцааг буцаан төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Засгийн газрын хувь оролцоо данс 91,638,757.9 мянган төгрөг болж өмнөх оноос 1,871,069.3 мянган төгрөгөөр буурсан нь ДХИС-ийн захирлын тушаалаар 69,197.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 32,934.6 мянган төгрөгийн тавилга эд хогшлын дахин үнэлгээний зөрүүг залруулснаас шалтгаалжээ.

Дотоод хэргийн их сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны орлогын дүн 16,532,296.3 мянган төгрөг болж өмнөх оноос 24,968,935.1 мянган төгрөгөөр буюу 39.8 хувиар буурсан, нийт зардал өмнөх оноос 18,403,365.6 мянган төгрөг болж өмнөх оноос 1,026,268.2 мянган төгрөгөөр буюу 5.9 хуваарь өссөн үзүүлэлттэй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Дотоод хэргийн их сургууль нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 21,349,373.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвөөс зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг 6,288,664.0 мянган төгрөгөөр бууруулж нийт 15,060,709.6 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Дотоод хэргийн их сургууль нь тайлант онд 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 15,060,709.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 14,214,059.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 840,750.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 5,900.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 14,193,602.2 мянган төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 1,062,454.4 мянган төгрөг бүрдүүлж, төлөвлөгөөнөөс 215,804.4 мянган төгрөгөөр давсан нь суралцагчдын тоо нэмэгдсэнээс шалтгаалжээ. Үндсэн үйл ажиллагааны орлого нь эрх зүй нийгмийн ухааны сургуулийн эрх зүйн анги, ахисан шатны боловсролын сургуулийн магистр, докторын сургалт, ахлагчийн сургуулийн гэрээт харуул, хамгаалалтын ажилтан бэлтгэх сургалтын төлбөрөөс бүртгэгдсэн байна.

Санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 3,670.5 мянган төгрөг, давсан орлого 215,804.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 15,036,581.7 мянган төгрөг буюу 99.8 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 495.0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 135.1 мянга, хангамж, бараа материалын зардлыг 456.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 21,229.3 мянга, бараа ажил үйлчилгээний бусад зардлыг 1,214.6 мянга, тээврийн хэрэгслийн татварын зардлыг 482.4 мянга, тээврийн хэрэгслийн оношилгооны зардлыг 289.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт:2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70713	Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын судалгаа шинжилгээ	15,060,709.6	15,036,581.7	24,127.9	99.8
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	13,103,025.7	13,099,355.2	3,670.5	100.0
1.2	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны аж	20,457.4	-	20,457.4	0.0
1.3	80220	Холбооны суваг ашигласны хөлс	8,800.0	8,800.0	-	100.0
1.4	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	856,838.6	856,838.6	-	100.0
1.5	81822	Гадаад суралцагсдын зардал	18,349.2	18,349.2	-	100.0
1.6	82308	Зэвсэгт хүчний сургалт	1,053,238.7	1,053,238.7	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 260,070.4 мянга, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 63,086.0 мянга, нийт 323,156.4 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 10,800.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 6,465.0 мянган төгрөг, норматив зардалд 97,340.4 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 78,000.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 40,848.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 81,686.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. Зарцуулагдаагүй үлдэгдэл 8,017.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Их сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд “IFT soft” ХХК-тай хамтран ажиллаж E-Mind сургалтын систем, E-office удирдлагын системийг тус тус нэвтрүүлж, Коронавируст халдварын үед хичээл, сургалтыг цахимаар зохион байгуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Ковид-19 цар тахлын өвчлөлтэй үед Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрээр нийслэл хотын хэмжээнд 2021 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Дотоод хэргийн их сургуулийн алба хаагч, сонсогчид цагдаагийн байгууллагатай хамтран хуваарийн дагуу үүрэг гүйцэтгэн ажилласан байна.

3.8 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.8.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 9 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтуудыг тус тус хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 159,246.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 69,421.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 89,825.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Албан шаардлага

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 69,421.3 мянган төгрөгийн бараа материалыг шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2."Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ." заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх.

4.2 Зөвлөмж

Илрүүлэлт

Цахим нэвтрэлтийн болон хичээлийн хэрэгслийн худалдан авалтыг худалдан авах ажиллагааны цахим хуудсанд байршуулж үнийн санал авахгүйгээр нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай 89,825.0 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33.1-т "Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно", 33.2-т "Харьцуулалтын аргыг дараах байдлаар хэрэглэнэ", 33.2.1-т "үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж:

Бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагаанд мөрдөх босго үнийг харгалзан, худалдан авах ажиллагааны аргыг зөв сонгож, гэрээ байгуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр, аудитын код	Алдаа зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
						Үүнээс		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар													
1	Дотоод хэргийн их сургууль АХГ-2022/333/НА-СТА-ТШЗ	ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдаагүй 69,421.3 мянган төгрөгийн бараа материалыг шууд худалдан авалт хийсэн.	Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.	1	89,825.0							1	89,825.0
2		Цахим нэвтрэлтийн болон хичээлийн хэрэгслийн худалдан авалтыг худалдан авах ажиллагааны цахим хуудсанд байршуулж үнийн санал авахгүйгээр нэр бүхий ААНБ-тай шууд гэрээ байгуулсан байна.	Албан шаардлагыг хэрэгжүүлэх, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх	1	69,421.3					1	69,421.3	-	-
Дүн				2	159,246.3					1	69,421.3	1	89,825.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал													
1	Дотоод хэргийн их сургууль АХГ-2022/333/НА-СТА-ТШЗ	Тайлант онд Шилэн дансны цахим хуудсанд 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн оруулж байх.	1								1	
Дүн				1								1	
Нийт дүн				3	159,246.3					1	69,421.3	2	89,825.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 43/20160062
АХГ-2022/59/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дотоод хэргийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 69,421,300.0 мянган төгрөгийн бараа материалыг шууд худалдан авалт хийсэн.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2."Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ." заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дотоод хэргийн их сургуулийн захирал, цагдаагийн хурандаа П.Батбаатар, Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч, хурандаа Ч.Лхагважав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ЭНХЖИН
Э.БҮГҮНҮТЭЙ